

**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04-р сарын 10-ны өдөр

Дугаар:25/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын зааланд 2025.04.10-ны өдрийн 16.00 цагт эхлэв.

“Хүрд” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж танилцууллаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаярын танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 114,143.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 11 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 84.38 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д "Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно" гэж заасныг бүрэн хангаж байгааг танилцуулж,хурал хуралдуудах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хуралд Э.Тэмүүжин, Б.Сумьяа, Б.Бат-Эрдэнэ, Ц.Эрдэнэсүх, Б.Мөнхбат, С.Мягмарсүрэн, Э.Ундрах, Э.Мөнх-Оргил, С.Пүрэвжав, Г.Алтансүх, Б.Лундаа нарын 11 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа ээлжит хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг Тооллогын комиссоос авч гишүүдэд мэдээлж, Хурлын удирдлага, хурлын нарийн бичгийг томилох /ХЗБ Комисс/
2. Хурлын ирц мэдээлэгдсэнээс хойш хурлын явцад хуралд ирэгсдийг бүртгэн авч, саналын хуудас олгохгүй.
3. Хурлаар хэлэлцэх асуудлын талаар хурал даргалагч /ТУЗ-ийн дарга/ Б. Мөнхбат танилцуулах
4. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан /Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин/
5. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулна. /Хурлын дарга/
6. Хэлэлцэж буй асуудлын талаар санал, асуулт хэлэлцэх. Хүн бүр 5 минут.
7. Хэлэлцэж буй асуудлаар санал хэлэхдээ зохисгүй, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, өөрийн саналыг бусдаар дэмжүүлэхийг уриалахгүй байх.

8. Хурлын үеэр чанга ярих, утсаар ярих, бичлэг хийхгүй байх
9. Хурлын явцад хурлыг түр орхиж гарах, чөлөө авах бол хурал даргалагчаас зөвшөөрөл авах
10. Хурлаар баталсан дэгийг зөрчсөн тохиолдолд хурал даргалагч эхний удаа сануулах, дараагийн удаа хурлаас чөлөөлөх арга хэмжээ авах
11. Тооллогын комисс саналын хуудсыг хүлээн авах.
12. Санал хураалтын дүн бүрээр тогтоол гаргаж, хуралд танилцуулах.
13. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж, тогтоолоо батлах.
14. Хурлыг 16:00 цагт эхэлнэ. Хурал 1 цаг үргэлжлээд 10 минут завсарлана. Хурлыг 1 цаг 30 минутад багтаах.
15. Хуралд оролцогчдын 75-с дээш хувийн саналаар хурлын цагийг сунгах.
16. Хурлын дарга үг хэлж хурлыг хаах.

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө, 2025 оны удирдлагын зардлыг батлах

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

1-р асуудал: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин танилцууллаа. Үүнд:

2024 онд Хүрд ХК 75 орчим хүний бүрэлдэхүүнтэй Хүрд Нарлаг, Хүрд Финанс охин компани болон Үйлдвэрлэлийн алба, Захирлын ажлын алба, Хангамжийн алба, Санхүүгийн алба, Авто бааз, Орон сууц контор болон төмөр хийц, бетон хийцийн цехийн бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

Тус хугацаанд Хүрд ХК-ийн хамт олон:

1. Эрчим Хүчний яамны захиалгатай Увс аймгийн Улаангом, Цагаанхайрхан, Зүүнговь, Завхан, Баруунтуруун, Өмнөговь сумын 6-0,4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг сайжруулах 5,212 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгсөн.

Өөрийн эзэмшлийн:

- Хүрд ХК-ийн Баянгол дүүргийн 20-р хороонд байрлах бетон хийцийн үйлдвэрийн агуулах болон захиргааны барилгын иж бүрэн засварын ажил.
- Хүрд ХК-ийн эзэмшлийн СБД-ийн 18-р хороонд байрлах ашиглалтгүй байгаа 12 айлын түрээсийн орон сууцны барилгыг буулгаж, түрээслэх объект барих

- Бусад үндсэн хөрөнгийн засварын ажлыг гүйцэтгэлээ.

Бид 2024 оны 5-6 сард Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн 16-р хороонд Ус хангамж, ариутгах татуургын шугамын ажлын 5 тэрбум 591 сая төгрөгийн төсөвтэй ажлын сонгон шалгаруултанд оролцож шалгарсан боловч сонгууль, сонгуулийн дараах засгийн газрын бүтэц, нэр өөрчлөгдсөн гэх мэт шалтгаанаар 2024 оны 10-р сард гэрээг албажуулан 2025 оны 2-р сард ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдоод байна.

Мөн 2023 онд сонгон шалгаруулалтаар авсан Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын шинэ суурьшлын бүс байгуулах инженерийн шугам сүлжээний ажил Захиалагч талаас бичиг баримтын иж бүрдэл хангаагүй шалтгаанаар ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй тул ажил царцаад байна. Тус ажлуудыг энэ онд хийж гүйцэтгэхээр зорьж байна.

Дээрх ажлын гүйцэтгэлээс 2.0 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил, Чингэлтэйн сервис центрийн барилга угсралтын ажлаас 6 орчим сарын хугацаа, боломж алдагдаад байна.

Энэ нь цаашид сонгон шалгаруултаар ажил үйлчилгээ авах ажлын хажуугаар бусад ажил үйлчилгээ худалдааг нэвтрүүлж мөнгөн орлогоо солонгоруулах шаардлагатайг ахин харуулж байна.

2024 оны компанийн мөнгөн орлогыг задалж харвал:

- БУА-ын ашиг : 444 сая төгрөг байна.
- Санхүүгийн үйлчилгээний ашиг Банкны хадгаламж, хувьцааны ашиг: 2 тэрбум 305 сая
- Түрээсийн ашиг: 162.6 сая төгрөг
- Спорт заалны ашиг: 164.05 сая төгрөг байна.

Бид 2024 оны 09-р сарын 12-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Хүрд Финанс ББСБ -г 2.5 тэрбум төгрөгийн дүрмийн сантайгаар байгуулж, холбогдох хууль, журмын дагуу бичиг баримтыг бүрдүүлэн 2025 оны 2 сараас үйл ажиллагаагаа эхлэн өнөөдрийн байдлаар 450 гаруй сая төгрөгийн зээл олгоод байна. Дундаж хүү 2.9 хувь, одоогоор чанаргүй зээлгүй байна.

2025 онд Хүрд Финанс ББСБ нь ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан 2.5 тэрбум төгрөгийн үйлчилгээ үзүүлэх, зах зээлд таниулах ажлыг хийхээр зорьж байна.

Компанийн эрх зүйн хувьд

Бид 2006 онд гүйцэтгэсэн 1-р хороолол-орбитын чиглэлийн цэвэр усны шугамын нэмэлт ажлын санхүүжилт 300 сая төгрөгийн төсөвт БХТ-ийн магадлалаар баталгаажуулан, Монгол Улсын ерөнхий аудиторын заавал хэрэгжүүлэх тушаал гаргасан хэдий ч өнөөдрийг хүртэл Сангийн яам, Барилгын яамны зүгээс төсөвт суулгаж санхүүжүүлээгүй байна.

Мөн БНХАУ-с жин тонн зөрүүтэй арматурын хэргийг ОУ-ын арбитрын шийдвэр манай талд гарсан боловч өнөөдрийг хүртэл БНХАУ-ын талаас ОУ-ын дэг журам зөрчин хуулийн дагуу арга хэмжээ аваагүй байна.

Үндсэн хөрөнгийн хувьд :

2024 онд үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах ажлыг эхлүүлснийг үргэлжлүүлэн СБ дүүргийн 12 айлын газарт объект барих, ХУД-т байрлах төмөр хийцийн цехийн байрыг засварлах, өргөтгөх, ахин төлөвлөх зэрэг ажлууд хүлээгдэж байна.

Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Бетон цехийн агуулахын барилгыг иж бүрэн засаж, 2024 оны 09-р сарын 12-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан гадаад худалдааны чиглэлээр Масо Экспо ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажил, суурь судалгааг гүйцэтгэх захирал Э.Ундрах хийж байна.

Компанийн харьяа орон сууц контор нь 30 хүний батлагдсан орон тоотой хэдий ч 2024 онд 18 хүний бүрэлдэхүүнтэй 2.6 тэрбум төгрөгийн үйлчилгээг 3000 гаруй айлд үзүүлж 250 гаруй сая төгрөгийн цэвэр ашигтай ажилсан байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн цалин, ашиг зэрэг зардлуудыг тооцож тариф баталж өгдөг тул ашгийн хэмжээг тогтоох, цалинг батлах зэрэг нь биднээс хамааралгүй хязгаарлагдмал байдаг.

Бид 2025 онд Дулаан, Цахилгаан, Сантехник угсралтын чиглэлээр нэмж 1-3 ажил авах, худалдаа нийлүүлэлтийн тендерт оролцох, худалдааны бизнес эхлүүлэх төлөвлөгөөтэй.

Цахилгаан, дулааны үнийн тариф нэмэгдсэн, бараа материал валютын ханш тогтворгүй байгаагаас хамаарч компанийн хэмжээнд ашиггүй зардлыг багасгах, зардал шаардаж буй хэрэгцээгүй техник, хэрэгсэл, бараа материалыг борлуулах актлах, тог ус цахилгааны хэрэглээг хэмнэх шаардлага байна.

Гадаад валют, үл хөдлөх, үнэт цаасны зах зээлийг идэвхтэй сонирхох, оролцох нөхцөл үүсээд байна.

2-р асуудал: Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хурлын дарга Б.Мөнхбат уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-д заасан шаардлагын дагуу хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Зууны мэдээ /, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 15 хоногийн давтамжтайгаар 2 удаа тус тус зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2024 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

2023 онд компанийн нэгж хувьцаанд **2256** төгрөг, нийт **304,348,500** төгрөгийн ногдол ашиг олгосон бол 2024 онд компанийн нэгж хувьцаанд **3550** төгрөг, нийт **480,194,300.0** төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2024 оны ажлын үр дүнд **"хангалттай"** гэсэн дүгнэлт өгснийг үндэслэн удирдлагын урамшуулал олгох журмын дагуу удирдлагын урамшилд **66,2 сая** төгрөг олгожээ.

2024 оны компанийн удирдлагын зардлыг **680,0** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл нь **520.3** сая төгрөг болж, **159.7** сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

Бид өнгөрсөн онд **4 тэрбум 738.3 сая** төгрөгийн БУА гүйцэтгэж, **1 тэрбум 960.7** сая төгрөгийн орон сууцны үйлчилгээний ажил, нийт **7 тэрбум 397.9** сая төгрөгийн барилга угсралт, ажил үйлчилгээ эрхэлж **6 тэрбум 953.9** сая төгрөгийн зардал гаргаж, барилга угсралтын хувьд **444 сая** төгрөгийн ашигтай, **1** төгрөгийн БУА-ыг **94** мөнгөөр гүйцэтгэж, барилга угсралтын хувьд 6%-ийн ашигтай ажиллажээ.

Дотоод аж ахуйн нэгжүүд: төмөр хийц **25,47 сая** төгрөг, бетон эдлэлийн үйлдвэр **136.76 сая** төгрөгний ажил үйлчилгээ, үйлдвэрлэл явуулж, материал хангамж **36.0 сая** төгрөгний гадагш борлуулалт хийж, түрээсийн орлого **162.6 сая** төгрөг, бусад ажил үйлчилгээнээс **164.0 сая** төгрөгийн орлого оруулсан байна.

Компанийн нийт борлуулалт 2024 онд **10 тэрбум 29.87 сая** төгрөг бөгөөд татварын өмнөх ашиг **2 тэрбум 277.9 сая** төгрөг, цэвэр ашиг **2 тэрбум 22.3 сая** төгрөг байна.

2024 онд бизнес төлөвлөгөөгөөр компани нийт **8 тэрбум 869,4** сая төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэх ба үүнээс **8,0 тэрбум 189.0** сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэж, **655,2** сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн ч нийт борлуулалт **10 тэрбум 29.4 сая** төгрөг бөгөөд цэвэр ашиг **2 тэрбум 22.3 сая** төгрөг байна нь төлөвлөгөөг биелүүлж ажилласныг харуулж байна.

Ажлын үр дүн, компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хангалттай гэсэн дүгнэлтийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх захирал Э.Тэмүүжинг сайн ажилласан гэж онцолж хэлмээр байна. Өнгөрсөн онд ашиглагдахгүй байсан үл хөдлөх хөрөнгийг эргэлтэд оруулсан, бетон эдлэлийн үйлдвэрийн конторын барилгыг бага зардлаар, өөрийн ажилчдын хүчээр засч байгаа, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авч үйл ажиллагааг эхлүүлсэн, шинэ бизнес санаа гаргаж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж, хэрэгжүүлж байгааг нь сайшаан тэмдэглэмээр байна.

3-р асуудал: Э.Тэмүүжин: Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын тооцоотой та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа.

Компанийн 2025 оны удирдлагын зардлыг тооцохдоо инфляцийн түвшин, ажилчдын цалингын нэмэгдэл, ажилгүй буюу өвлийн амралтын үеийн цалинг /урамшуулал/ мөн үндсэн хөрөнгийн засварыг тооцож гүйцэтгэх удирдлагын зардлыг, Хүрд ХК-ийн охин компануудын хөгжил болон компанид нэн дутагдалтай байгаа хууль эрх зүй, дотоод аудит маркетингийн зардлыг тооцож ТУЗ-ийн зардлыг гаргалаа.

Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Өнгөрсөн оны ажлын үзүүлэлт түрүү жилийнхээс буурсан байгааг тайлбарлана уу? Мөн ашгийн дүн ч буурчээ.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Манай компани өнгөрсөн онд 1 тендерт 8-р сард шалгарсан боловч гэрээ хийх ажил хойшилсоор 10-р сард хийгдсэн. Сонгууль, шинэ зохион байгуулалттай холбоотойгоор бүх ажил удааширч, яамны нэр солигдсон гэх мэт шалтгаанаар барилга угсралтын ажил эхлэх зөвшөөрөл олгогдоогүй он гарсан. Мөн Сүхбаатар аймгийн Баруун-урт хотын шинэ суурьшлын бүс байгуулах инженерийн шугам сүлжээний ажил Захиалагч талаас бичиг баримтын иж бүрдэл хангаагүй шалтгаанаар ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй тул ажил царцаад байна. Энэ 2 ажлыг гүйцэтгэж эхлээд санхүүжилтээ авсан бол борлуулалт өндөр гарах байлаа.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Банкны хүүгийн орлого 300,0 сая төгрөгөөр буурсан. Шалтгаан нь юу вэ?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Банкны бодлогын хүү буурсантай холбоотой. Банкууд урьд нь 18-20% хүү санал болгодог байсан бол одоо 15-16% байна.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Хүрд Нарлаг ХХК ямар үйл ажиллагаа явуулж байгаа вэ?. Компанийн үйл ажиллагааны тайланд Хүрд Нарлаг ХХК-ийн талаар дурдагдсангүй.

Хувьцаа эзэмшигч, нягтлан бодогч Б.Сумьяа: Хүрд Нарлаг ХХК тусдаа данстай, баланс гаргаад явдаг компани

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Засгийн газрын тогтоолын дагуу цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байгаа. Баянзүрх орон сууцны 1-р давхрыг Боловсролын яамтай гэрээ байгуулан цэцэрлэгийн зориулалтаар түрээсэлж байгаад, үйл ажиллагаа нь зогссон байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Хүрд Нарлаг ХХК-ийн хөрөнгө компанийн хөрөнгө биз дээ. Тусдаа данстай ч компанийн өмч тул нэгдсэн тайлан гаргах ёстой гэдгийг би өнгөрсөн жилийн хурал дээр хэлж байсан. Сүхбаатар дүүргийн 12 айлын орон сууцны барилгыг буулгаад юу барьж байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Сэндвичээр машин угаалгын газар барьж байгаа. Хүрд финансын үйл ажиллагаа 2025 оны 2-р сард эхэлсэн. Банк бус санхүүгийн байгууллагын бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх шаардлагатай юу?

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг ТУЗ удирдана.

а нь Санхүүгийн Зохицуулах хороо, Монгол банкны хяналттай байгууллага тул бид итгэдэг. Банк бус санхүүгийн байгууллага байгуулж, өөрийн үйл ажиллагаанд ашигтай байдлаар зохицуулж ажиллах хэрэгтэй. Компанийн газарт орон сууц барих асуудал ямар шатандаа байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Орон сууц барих төлөвлөгөө хэвээрээ. Тэгэхдээ мөнгө санхүү нь байгаа ч зах зээлийн нөхцөл байдал тогтворгүй байгаагаас харзнаж байна. Арматурын үнэ буурах уу, Шатахуун тасалдалгүй энэ хэвээрээ байх уу гэх мэт асуудал байна.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Хотын төвийн А бүсэд 7 давхраас дээш орон сууц барихыг хориглосон байгаа. Энэ бодлого хэр удаан үргэлжлэх үү гэдгийг бас харах хэрэгтэй болж байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Охин компанийн тайлан, үйл ажиллагааг хурал дээр бүрэн танилцуулж байхыг хүсье. Увс Хийц ХХК-ийн үйл ажиллагаа юу болсон бэ? Зах юм байна. Тийм үү?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Увс Хийц ХХК нь хүмүүсийн хувь нийлүүлсэн компани. 20% нь л манай компанийн эзэмшилд байсныг зарсан. Үйл ажиллагаа явуулдаггүй, балгас болсон барилга. /Интернетээс татаж, барилгын зургийг харуулав/

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Бүртгэлтэй хөрөнгийн талаар тодорхой мэдээлэл өгч байхгүй бол бидэнд хөрөнгөө яасан юм бол гэх хардлага төрж байна аа.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Түрээсийн орлогоос гадна бусад орлого гэсэнд ямар орлого орсон бэ?

Хувьцаа эзэмшигч, нягтлан бодогч Б.Сумьяа: Баянзүрх орон сууцны 1-р давхрыг цэцэрлэгийн үйл ажиллагаагаар түрээсэлж байсны 2024 оны эхний 5 сарын орлого юм.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Энэ оноос эхлэн Баянзүрх дүүргийн 5 орон сууцыг түрээсийн орон сууц маягаар ашиглахаар шийдээд байгаа. Тохижуулах гэж бас зөндөө л зардал гарч байна. Орон сууц барьж байхда 1-2 давхраар нь түрээслэх байсан юм билээ. Солонгос ийм маягаар түрээсэлдэг орон сууц байдаг юм билээ.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Компанийн газарт орон сууц барих ерөнхий төлөвлөгөөгөө батлуулсан уу? Хөршүүд барилга тулгаад бариад эхэлбэл хэцүү дээ.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Бизнес төлөвлөгөө боловсруулахдаа одоо байгаа дээрх 2 ажил дээр нэмж ажил авах, худалдаа нийлүүлэлтийн тендер

оролцоно гэж төлөвлөж, 11,5 тэрбум төгрөгийн борлуулалттай байхаар төлөвлөсөн.

Удирдлагын зардлыг боловсруулахдаа цалингийн хэмжээг нэмэгдүүлж тооцсон. Бусад унаа, томилолт, хүлээн авалтын зардлыг багасгасан. Хэмнэх боломжтой зардлуудыг танасан. ТУЗ-ийн даргын цалинг сард 3,0 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүдийн цалинг хурлын ирцээр буюу улиралд 1 удаа хуралдахаар тооцсон байгаа. Өөр асуулт, санал байна уу?

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Өөр асуулт, санал байхгүй бол Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2025 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах, ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал хураалт явагдав.

Тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр саналын хуудсыг хураан авч, саналын хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар.

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **114,143.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**

2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **144,143.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**

3. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө батлах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **144,143.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**

4. 2025 оны удирдлагын зардлыг батлах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **144,143.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**

ХУРЛЫН ШИЙДВЭР:


Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлав.

Хурлын дарга Б.Мөнхбат тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслүүдийг гишүүдэд уншиж танилцуулж батлуулав.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 17.20 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХЯНАСАН
ХУРЛЫН ДАРГА  Б.МӨНХБАТ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Г.ГАНТУЯА